



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

20 20 оны 08 сарын 26 өдөр

Дугаар А/80

Алтай хот

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, 32 дугаар 32.7 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалт, Үнэлгээний хорооны 2020 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн 116 дугаар зөвлөмжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сангийн Ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн хөтөлбөрийн санхүүжилтээр хийгдэх ГААОНӨГ/202007125 дугаартай Есөнбулаг сумын Баяншанд багт шинээр байгуулагдаж буй худгийн хайс хамгаалалтын бүс ажлыг "БГБС" ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлэх эрхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ч.Бат-Эрдэнэ)-т олгосугай.

2.Гүйцэтгэгчийн санал болгосон ажил гүйцэтгэх хугацаа, ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолт зэргийг үндэслэн холбогдох хууль, журмын дагуу эрх үүрэг захиалагчийн хяналт, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгаж, хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ч.Бат-Эрдэнэ), Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (М.Ууган-Эрдэнэ)-т тус тус үүрэг болгосугай.

3.Санхүүжилтийн гүйцэтгэл, ажлын чанарт хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ч.Бат-Эрдэнэ)-т, Мэргэжлийн хяналтын газар (Г.Гантулга)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Ж.ГАНБАТ



C:/My documents/ZAHNR-3A-4 doc

0201001203